

1. “НОГООН ХЭРЭМ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН СУДАЛГАА

2017. 12. 12

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	Төсөл, хөтөлбөрийн нэр	“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр
2	Хэрэгжүүлэгч байгууллага	Монгол улсын Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн ажлын алба
3	Хөтөлбөрийн зорилго	Уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалж ойн сан хомсдох, цөлжилт, элсний нүүлт, шар шороон шуурга улам эрчимжиж байгаа экологийн өнөөгийн сөрөг нөлөөллийг багасгаж, цөлжилт, элсний нүүлтийг сааруулах ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгоход байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц бодлого, арга хэмжээг бүс нутгийн онцлогт тохируулан урт хугацааны турш үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх үндсэн дээр Монгол орны говь, хээрийн бүсийн заагийг бүрэн хамарсан ногоон зурвас, ногоон төгөл байгуулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.
4	Хэрэгжих хугацаа нийт	Нийт 2005-2035 1-р үе шат: 2005-2015 2-р үе шат: 2015-2025 3-р үе шат: 2025-2035
5	Хэрэгжилтийн явц	“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2005-2017 онд 12 сумын нутаг дэвсгэрт 149564,0 мянган төгрөгний хөрөнгө оруулалтаар 129,4 га талбайд 68094 ширхэг мод, сөөг тарьж 81,9 хувьтай ургаж байна. 2017 онд Сайнцагаан, Сайхан-Овоо, Дэлгэрцогт, Луус, Эрдэнэдалай, Гурвансайхан сумдын нутагт 10 га талбайд тарьж ургуулсан ойн зурвасын ажлыг Аймгийн Засаг даргын А/306 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гүйцэтгэлийг актаар хүлээн авлаа. Амьдралтын түвшин 80-82,5%.
6	Хүлээгдэж буй үр дүн	- Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр аймаг болон сумын төвийг элсний нүүдэл, тоосжилт, шар шороон шуурганаас тодорхой хэмжээнд хамгаалж, агаарын бохирдлыг бууруулна. - Монгол улсад тулгараад байгаа байгаль орчны асуудал(уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт) шийдвэрлэх болон ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулах - Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах болон байгаль орчны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх

2. САЙХАН-ОВОО СУМЫН УНДНЫ УСНЫ НӨӨЦ ТОГТООХ ГЕОФИЗИЗИЙН ХАЙГУУЛ СУДАЛГАА

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	Төсөл, хөтөлбөрийн нэр	Сайхан-Овоо сумын ундны усны нөөц тогтоох геофизикийн хайгуул судалгаа
	Захиалагч байгууллага	Монгол улсын Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам,
2	Гүйцэтгэгч байгууллага	“Ус–Амьдрал” ХХК
3	Хөтөлбөрийн зорилго	Уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалж ойн сан хомсдох, цөлжилт, элсний нүүлт, шар шороон шуурга улам эрчимжиж байгаа экологийн өнөөгийн сөрөг нөлөөллийг багасгаж, цөлжилт, элсний нүүлтийг сааруулах ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгоход байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц бодлого, арга хэмжээг бүс нутгийн онцлогт тохируулан урт хугацааны турш үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх үндсэн дээр Монгол орны говь, хээрийн бүсийн заагийг бүрэн хамарсан ногоон зурвас, ногоон төгөл байгуулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.
4	Хугацаа	2017 он
5	Хэрэгжилт	Тус сумын төвөөс хойш Дугана тээг, сумын төвөөс урагш Сэнжит, сумын төвийн баруун тал Онги голын баруун тал зэрэг 3 газар судалгаа хайгуулын ажлыг хийсэн. Сэнжит, Дугана тээг гэдэг 2 газар өрөмдөж судалгаа хийхэд сумын төвийн усны хангамж нөөц нь бага усны чанар унданд хэрэглэхэд тааруухан гэж гарсан учир сумын төвөөс баруун тийш 2км орчим Онги голын баруун талд өрөмдсөн. Усны нөөц болон ахуйн хэрэглээнд найрлага нь тохирсон гэж тогтоогдсон тул тухайн газраас 400 метрийн зайд дахин өрөмдлөгийн ажлыг хийж 5 л/с ундаргатай усны нөөц тогтоов.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР